

**ПАРЛАМЕНТЫН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЫГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ ТАЛААР  
БУСАД ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ДЭГИЙН ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

Хүснэгт

	Улсын нэр	Эрх зүйн зохицуулалт
1.	Герман	<p><b><u>ХБНГУ-ын Бундестагийн хуралдааны дэг</u></b></p> <p><b>16 дугаар зүйл. Баримт бичигтэй танилцах</b></p> <p>1.Нууцын зэрэглэлтэй баримт бичигтэй холбоотой асуудлыг “Германы Бундестагийн нууц хамгаалах журам”-аар зохицуулна</p> <p><b>17 дугаар зүйл. Нууц хамгаалах журам</b></p> <p>Бундестаг нь “Нууц хамгаалах журам”-ыг батлан мөрдөх бөгөөд журам нь Бундестагийн хуралдааны дэгийн бүрэлдэхүүн хэсэгт тооцогдоно (хавсралт3). Журмын зорилго нь эрх олгогдоогүй, эсхүл зөвшөөрөлгүй этгээд нууц мэдээлэл олж авах болон нууцыг задруулахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэрэгслийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд чиглэнэ.</p>
2.	Киргиз	<p><b><u>БНКУ-ын Жогорку Кенешийн регламент</u></b></p> <p><b>36 дугаар зүйл. Жогорку Кенешийн хаалттай хуралдаан</b></p> <p>7.Төрийн болон хуулиар хамгаалагдсан бусад нууцыг бүрдүүлэх материалыг хадгалах, нэвтрэх, нууцлах журмыг Жогорку Кенеш-ээс баталсан журмаар тогтооно.</p>
3.	ОХУ	<p><b><u>ОХУ-ын Төрийн Думын регламент</u></b></p> <p><b>37 дугаар зүйл.</b></p> <p>8.Төрийн Думын хуралдаанд дээр хэлэлцсэн төрийн болон бусад нууцад хамаарах асуудлыг нийтэд зарлахыг хориглоно.</p> <p>9.Хаалттай хуралдааныг даргалагч нь хуралдаан эхлэхийн өмнө Төрийн Думын депутатууд, хаалттай хуралдаанд уригдсан зочдод хаалттай хуралдааныг явуулах журам, тухайн хурлаар хэлэлцэх нууц асуудал, түүний нууцын зэрэглэлийн талаар тайлбарлаж, төрийн болон бусад нууцад хамаарах мэдээллийг задруулвал хүлээх хуулийн хариуцлагыг тайлбарлана.</p> <p>10.Төрийн Думын хаалттай хуралдааны тэмдэглэл, хаалттай хэлэлцсэн асуудалд хамааралтай материал, цахим системийн санал хураалтын дүн, хаалттай хуралдаанд оролцсон гишүүдийн ирцийн мэдээг Төрийн Думын нууцын асуудал хариуцсан нэгжид хадгална. Эдгээр материалтай нууцын баталгаа гаргаж танилцаж болно.</p> <p><b>102 дугаар зүйл.</b></p> <p>Техникийн үйлчилгээний бүлгийн ахлагч Төрийн Думын депутатад түүний бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Төрийн Думын хаалттайгаас бусад хуралдааны талаарх мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй. Техникийн үйлчилгээний бүлэг нь Төрийн Думын Тамгын газрын төрийн нууцыг хамгаалах үүрэг бүхий нэгж юм.</p>
4.	Солонгос	<p><b><u>БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухайн хууль</u></b></p> <p><b>62 дугаар зүйл. Хаалттай хурлын тэмдэглэлтэй танилцах болон гадагшаа гаргахыг хориглох</b></p>

		<p>Гишүүн хаалттай хурлын тэмдэглэл болон түүнтэй холбоотой нууц материалыг авах хүсэлт гаргасан тохиолдолд хяналт шалгалтад харшлахгүй бол хорооны дарга нь зөвшөөрнө. Материалыг Ассамблейгаас гадагш гаргаж болохгүй.</p> <p><b>70 дугаар зүйл. Хорооны баримт бичгийг хэвлэх болон удирдах</b></p> <p>5.Хорооноос бий болсон, эсвэл хороонд хүргүүлсэн нууц бичгийг хадгалж хариуцахтай холбогдсон асуудлыг энэ хуулиар тогтоогүй бол Үндэсний Ассамблейн Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвшөөрлөөр Үндэсний Ассамблейн спикер тогтооно.</p>
5.	Финланд	<p><b><u>Финландын Парламентын хуралдааны дэг</u></b></p> <p><b>Зүйл 43а. Хорооны баримт бичгийг нийтлэх</b></p> <p>Хорооны тэмдэглэлийг мэдээллийн сүлжээнд байршуулж нийтэд нээлттэй байлгана. Асуудлыг хэлэлцэх бэлтгэлтэй холбоотой баримт бичгийг тухайн асуудал хороогоор шийдвэрлэгдсэний дараа нийтэд нээлттэй болгоно. Хэрэв нууцын зэрэглэлтэй биш бол хороонд болон хорооны ажлын хэсэгт төлөөлөлгүй парламентын бүлэг шийдвэрлэгдэж буй асуудалтай холбоотой баримт бичгийн хуулбарыг авах эрхтэй.</p> <p>Хэрэв хорооны баримт бичиг Финландын олон улсын харилцаа, хөрөнгө санхүү, санхүүгийн зах зээлд ноцтой хохирол учруулахаар бол тухайн мэдээллийг нийтэд задлахгүй. Олон нийтийн ашиг сонирхол баримт бичгийг нийтэд ил болгохыг шаардсанаас бусад тохиолдолд хэрэв баримт бичиг нь худалдааны нууц, мэргэжлийн мэдээлэл, хувь хүний эрүүл мэндийн байдал болон санхүүгийн байдал зэргийг агуулж баримт бичгийг ил болгосноор тухайн этгээдүүдэд ноцтой хохирол учруулахаар бол баримт бичгийг нууцална. Хороо нь дээрхтэй адил шалтгаанаар баримт бичгийг нууц хэвээр байлгаж болно.</p> <p>Үндсэн хуулийн 50.3 дугаар зүйлд заасны дагуу хороо баримт бичгийг нууцын зэрэглэлтэй гэж зарласан бол баримт бичгийг нууцална. Засгийн газар Финландын гадаад харилцаа, эсхүл Европын Холбоонд хамаарах асуудлыг нууцын зэрэглэлд байлгах хүсэлт гаргасан тохиолдолд хороо хүсэлтийн талаар шийдвэр гарах хүртэл тухайн асуудлыг нууцална.</p> <p>Хэрэв хороо хугацааг богиносгох тухай шийдвэр гаргаагүй бол хорооны нууцын зэрэглэлд оруулсан баримт бичгийг нууцлах хугацаа Засгийн газрын үйл ажиллагаа ил тод байх тухай актын 31 дүгээр зүйлд (621/1999) заасантай адил байна.</p> <p>Спикерийн зөвлөл хорооны баримт бичгийг нийтэд ил болгохтой холбоотой нарийвчилсан удирдамж гаргаж болно.</p>